

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ГХУССЗ-ИЙН 2019 ОНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2019.12.23

Рашаант

Зорилго: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгжүүд, иргэдийг татан оролцуулж тэдний оролцоог сайжруулах, тэдгээрт хууль зүйн мэдлэг мэдээллийг зохих шат дараалалтайгаар олгох, хууль эрхийг сурталчилж зөвөөр ойлгуулан таниулах, нийт иргэдэд түүнийг даган мөрдөхийг уриалан гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад оршино.

Д/Д	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Төсөв хөрөнгө /эх үүсвэр/	Хэрэгжилт	Биелэлт
1	ГХУССЗ-ийн хурлаа хийж, 2019 оны ажлын төлөвлөгөөг гарган, ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар батлуулах.	2019.02 сард	ГХУССЗ-ийн НБДарга	Төсөв шаардахгүй	Төлөвлөгөө туулан хэрэгжүүлсэн	100%
2	“Монгол цэргийн баяр” арга хэмжээг зохион явуулах.	2019.03.16-18-ны өдөр хүртэл	Цагдаагийн хэсэг, Эрэгтэй чүүдийн зөвлөл	Өлзийт сумын УБ хот дахь нутгийн зөвлөлөөс	“Монгол цэргийн баяр” арга хэмжээний тусгай хөтөлбөрөөр зохион байгуулсан.	100%
3	Сумын баг, албан байгууллага, ААН-үүдийн дунд “Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон” шалгаруулах 3 сарын хугацаатай аян зарлаж урамшуулах.	2019 оны 2-р улиралд	Цагдаагийн хэсэг, ГХУССЗөвлөл	Сумын ИТХурал, ЗДТГазар /500.000/	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарна	70%
4	Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд “Камержуулалт, гэрэлтүүлэг” арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах.	2, 4-р улиралд	Цагдаагийн хэсэг, ГХУССЗ-ийн гишүүд	50.000 Хандив	Камерын хяналт, гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, ЕБС-ийн спорт зааланд 8 камер суулгаж, бүх байгууллагуудын гадна гэрэлтүүлгийг шинэчилсэн.	100%

5	Иргэд, аж ахуйн нэгжийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах зорилгоор “Урамшуулалт эргүүл”, “Гудамжны ахлагч” – ийн зардлыг шийдвэрлүүлж, ажиллуулах.	Тогтмол	Цагдаагийн хэсэг, 6-р багийн засаг дарга	ИТХурал, 3ДТГазар /200.000/	“Гудамжны ахлагч” аравтын зарчмаар байнгын эргүүл, хяналтыг уламжлал болгон 3 дахь жилдээ хэрэгжүүлж байна.	90%
6	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарт зан үйлд нь нөлөөлөх сайн дурын сургалтыг сургагч багшаар оролцуулан явуулах.	2-р улиралд	Хамтарсан баг, Цагдаагийн хэсэг	250.000 Хандив	Сумын хамтарсан багтай хамтран 1 удаагийн сургалт зохион байгуулсан ба зорилтот 30 иргэн хамрагдсан.	90%
7	Цагдаагийн хэсгийг согтуурал хэмжигч багажаар хангах	3-р улиралд	ГХУССЗ-ийн дарга, сумын засаг дарга	1.800.000 ОНХСан	Хөрөнгийн асуудал шийдэгдээгүй	Үнэлэх боломжгүй
8	2018 онд гэмт хэрэгт холбогдсон болон гэмт хэрэгт холбогдож болзошгүй иргэдэд хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулах.	1-р улиралд	Цагдаагийн хэсэг, ГХУССЗ	50.000	ГХУС болон БО-ны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 4 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 260 иргэнд зохион байгуулсан.	100%
9	Нийтээр тэмдэглэх баяр, ёслол /наадам, цагаан сар, шинэ жил, эх үрсийн баяр, цэргийн баяр, март-8/, урлаг, спортын тоглолт, бусад томоохон арга хэмжээний үеэр гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах чиглэлээр олон нийтийн эргүүл ажиллуулах.	Тухай бүр	Цагдаагийн хэсэг	Төсөв шаардлагүй	Гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.	100%

10	Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн аюулгүй байдал, соёл, хүмүүжлийг сайжруулах чиглэлээр сургууль, цэцэрлэгийн бүсийг аюулгүй болгох ажил, арга хэмжээг зохион байгуулах.	1, 3-р улиралд	Цагдаагийн хэсэг, СНА, ЕБС, СӨБ-ын захирал, эрхлэгч нар	ЕБСургууль, Цэцэрлэгээс 300.000	Сургууль, дотуур байрны орчмын бүс дэх авто замыг хааж, анхааруулах тэмдэг, самбар байрлуулан хүүхдийн аюулгүй байдлыг хангасан.	100%
11	Хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл түүний хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтыг төрийн албан хаагч, иргэд, ЕБС-ийн сурагчдад зохион байгуулах.	Тухай бүр	Цагдаагийн хэсэг	50.000	ЕБС-ийн сурагчдад 2 удаагийн сургалт, арга хэмжээ зохион байгуулсан	100%
12	Өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн сурагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Залгамжлагч-2019”, “Хүүхэд хууль-2019” тэмцээнүүдэд хамруулах.	2-р улиралд	Цагдаагийн хэсэг, СНА	400.000 хандив	Өсвөрийн сэргийлэгч нарын мэдлэг дээшлэнэ.	90%
13	Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр “Малчдын бүлэг”, “Хөршийн хяналт”, “Ахмадын оролцоо” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.	Жилдээ	Цагдаагийн хэсэг, БЗД нар	50.000	ИТХ-аас гаргасан 2 удаагийн гарын авлагад ГХУС чиглэлээр сэрэмжлүүлэг, тараах материал боловсруулан оруулж бүх айл өрхөд тараасан.	90%
14	ОУ-ын эх үрсийн баярыг “Тээврийн хэрэгсэлгүй өдөр” болгон зарлаж, арга хэмжээ зохион байгуулах.	2019.06.01	ГХУУСЗ, Цагдаагийн хэсэг, СНА	100.000 Хандив	Уламжлал болгон 3 дахь жилдээ зохион байгуулж хэвшиж байна.	100%

15	Зам тээврийн осол, бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурталчилгааны самбар, зорилтот шторк, санамж сэрэмжлүүлэг хийж олон нийтэд сурталчилах.	Жилдээ	Цагдаагийн хэсэг, ЭМТөв	150.000 ИТХурал, ЗДТГазар, ЭМТөв	Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил бууруулах зорилгоор брошур, өөрсдийн бэлтгэсэн болон бэлэн видео сурталчилгааны материалыг сумын FACEBOOK группэд тогтмол оруулж байна.	90%
16	Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр малчдын бүлэг нөхөрлөлийн уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж, бүлгийн ахлагч нарыг үнэмлэхжүүлэх, зөвлөгөөнөөс шийдвэр гаргаж, түүнийг хэрэгжүүлэх.	2-р улиралд	Цагдаагийн хэсэг, ГХУССЗ	250.000 Хандив малчдаас	Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарна.	70%
17	Архи согтууруулах ундаа, тамхи худалдан борлуулдаг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, норм, стандартыг хангуулах.	Тухай бүр	Цагдаагийн хэсэг, ХЭАБайцаагч	Төсөв шаардахгүй	Хуваарийн дагуу төлөвлөгөөт хяналт хийгдэж байгаа	90%
18	Хууль бусаар ашигт малтмал олборлох, хайх ажиллагааг таслан зогсоох чиглэлээр мэргэжлийн байгууллага, албан туушаалтантай хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчилд хуулийн дагуу арга хэмжээ авах.	Тухай бүр	Цагдаагийн хэсэг, БОХУБайцаагч,	Тодорхойгүй	Аймгийн МХГ, Цагдаагийн газартай хамтарсан хяналт, шалгалтыг нийт 4-5 удаа зохион байгуулж, хууль бусаар ашигт малтмал олборлолтыг	100%

					зогсоосон.	
19	“Алдуул мал болон хулгайлагдсан малыг бүртгэх, мэдээлэх журам”, “Мал эмнэлэг ариун цэвэр-гарал үүслийн гэрчилгээ түүнийг хэрэглэх журам”-ын хэрэгжилтэнд хяналт тавих.	Тухай бүр	Цагдаагийн хэсэг, МЭ-ийн тасаг	Төсөв шаардахгүй	2018 онд анх гаргасан “Малын им тамга” гарын авлагыг шинэчлэн гаргаж бүх малчин өрхүүдэд тараан ажилласан.	100%
20	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж, тайлан холбогдох материалыг Аймгийн ГХУСАЗСЗ-д заасан хугацаанд хүргүүлэх.	2019 оны 06, 12 сард	ГХУССЗ-ийн дарга, НБДарга	Төсөв шаардахгүй	Ажил дүгнэгдэнэ.	100%
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ						93,7%

ӨЛЗИЙТ СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ